

Санхүүгийн мэдлэг ба санхүүгийн боловсролын ялгааг дүгнэх нь

Монгол банкны оюутны эрдэм шинжилгээний хуралд зориулав

Гүйцэтгэсэн: П.Энхболд
“Мандах бүртгэл” дээд сургууль
Нягтлан бодох бүртгэл мэдээллийн систем, 3-р курс

И-мэйл хаяг: Enkhbold0220@gmail.com
Холбоо барих утас: 99239077, 94154393

Улаанбаатар хот

2016 он

Агуулга

- ❖ Оршил
- ❖ Онол
- ❖ Судалгаа
- ❖ Дүгнэлт
- ❖ Ном зүй

Оршил

Дэлхийн эдийн засаг, санхүүгийн хурдацтай хөгжлийг даган санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ илүү хөгжиж боловсронгуй болсоор байна. Энэхүү хурдацтай хөгжилтэй хөл нийлүүлэн алхах нь улс орон, үндэстний хувьд нэн тэргүүний асуудал юм. Хөгжиж буй болон бага буурай улс орнуудын хувьд ядуурлын түвшин өндөр байгаа нь хөгжлийн хурдац, эдийн засгийн өсөлтөнд сөрөг нөлөө үзүүлсээр байна. Тиймээс улс орнуудын ядуурлын түвшинг бууруулах, ядуурлаас гаргах хамгийн зөв арга зам бол санхүүгийн боловсрол гэдгийг дэлхийн хөгжингүй орнууд дуу нэгтэйгээр санал нэгдэх болсон. Олон жилийн туршид хэлэлцэж яригдаж ирсэн “Санхүүгийн боловсрол олгох үндэсний хөтөлбөр” Монгол улсын хувьд 2015 онд “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр” нэртэйгээр батлагдаж 2016-2021 он хүртэл хэрэгжих төлөвлөгөөтэй байна.

Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь оролцогч талуудын хамтын ажиллагааны тэнцвэртэй байдлыг хангаж, авч буй арга хэмжээ, үйл ажиллагааны давхардлыг арилгах, нэн шаардлагатай арга хэмжээнд төвлөрөх боломжийг олгох зэрэг давуу талыг бий болгодог. Тус хөтөлбөр хэрэгжсэнээр иргэдийн санхүүгийн сахилга батыг сайжруулах, санхүүгийн зөв шийдвэр гаргах чадварыг дээшлүүлэх, урт хугацаатай хуримтлал болон санхүүгийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, санхүү, банкны системд итгэх олон нийтийн итгэлийг дээшлүүлэх, цаашлаад Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлт хөгжлийг дэмжих боломжтой болно гэж Монгол улс дахь хөтөлбөрийн зохион байгуулагчид дүгнэсэн байна. Олон улсын амжилттай хэрэгжсэн боловсролын хөтөлбөрүүдийг дүгнэвэл хэрэглэгчид хандсан, суурь ойлголтоос эхэлсэн, энгийн ойлгомжтой бөгөөд сонирхолтой харилцаа холбоо бүхий байдлаар хэрэгжсэн байна.

Энэхүү санхүүгийн боловсрол хэмээх ойлголт олон нийтийн дунд яригдаж эхэлсэн мөн санхүүгийн боловсрол олгох хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа бодит туршлага дээрээс үндэслэн харахад иргэд, олон нийтийн дунд багахан төөрөгдөл байгаа бөгөөд юуны түрүүнд иргэдэд санхүүгийн мэдлэг болон санхүүгийн боловсролын төсөөтэй болон ялгаа байдлын талаар зөв ойлголтыг суулгаж өгөх нь нэн тэргүүний асуудал болоод байна.

Онол

Санхүүгийн боловсрол гэдэг нь нийгэм, эдийн засгийн тодорхой нөхцөлд өөрийн санхүүгийн эрх ашигт бүрэн нийцсэн үйл ажиллагаа явуулах дотоод чадамж юм. Энэ ойлголтод иргэд өөрсдийн нөөц бололцоог зөв үнэлэх, ашиглах, өөрсдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн санхүүгийн үйлчилгээний талаар мэдээлэл олж авах, сонголт хийх, шийдвэр гаргахдаа түшиглэж буй мэдлэг, чадвар болон итгэл үнэмшилийг багтаана. Энд:

- “Мэдлэг” гэдэг нь иргэн хувийн санхүүгийн талаар ойлгодог байх;
- “Чадвар” гэдэг нь санхүүгийн талаар мэдлэгээ өөрийн санхүүг удирдахад ашиглах;
- “Итгэл үнэмшил” гэдэг нь хувийн санхүүгийн шийдвэр гаргахдаа өөртөө бүрэн итгэлтэй байхыг тус тус хэлнэ.

Санхүүгийн мэдлэг гэдэг нь хувь хүний санхүүгийн зах зээл, санхүүгийн үйлчилгээ, санхүүгийн бүтээгдэхүүний талаарх ойлголтыг хэлэх ба санхүүгийн боловсролын нэг бүрэлдхүүн хэсгийг илэрхийлдэг нэр томъёо юм.

Хүн ам санхүүгийн илүү боловсролтой байх нь хэнд хэрэгтэй вэ:

- ❖ Хэрэглэгчийн хувьд – Өөрт тохирсон санхүүгийн бүтээгдэхүүнийг ашиглаж үр өгөөжийг нь илүү хүртэнэ, хэт их өр төлбөр бий болгох магадлал багасна, мөн санхүүгийн залилан, гэмт хэргийн хохирогч болох магадлал буурна.
- ❖ Санхүүгийн үйлчилгээний салбарын хувьд – Илүү мэдээлэлтэй, оролцоотой хэрэглэгчид нь санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг худалдан авах хавьгүй өндөр магадлалтай тул бизнесийн үйл ажиллагаа тэлэх, маркетингийн зардал буурах, санал гомдол цөөрөх зэрэг эерэг үр дагавартай.
- ❖ Ажил олгогчдын хувьд – Мөнгөний хямралд орсон, өдөр тутмын хэрэглээнд санаа зовсон ажиллагсадын бүтээмж доогуур байдаг ба ухаалаг хэрэглэгч, хувийн санхүүгээ удирдаж эзэн нь болсон, санхүүгийн эрх чөлөөтэй хувь хүн нь чөлөөтэй сэтгэж ажилдаа анхаарал төвлөрөлт сайн байх ба түүнийг даган ажлын бүтээмж өснө.
- ❖ Боловсрол олгогчдын хувьд – Мөнгөний утга учрыг ойлгосон, мөнгөнд хэт хамааралгүй, сурах зорилгыг эрхэм болгосон суралцагч нь хариуцлагатай бүтээлч байна.
- ❖ Төрийн бус байгууллагуудын хувьд – Хүн амын дэмжлэг хэрэгтэй бүлгийн хувьд санхүүгийн асуудалтай байх тохиолдол түлхүү бөгөөд тэдгээрийн санхүүгийн мэдлэг, боловсрол дээшилснээр тодорхой чиглэлийн Төрийн бус байгууллагууд үндсэн зорилгодоо хүрэхэд илүү дөхөм болно.
- ❖ Төв банк ба Засгийн газрын хувьд – Санхүүгийн чадавхи бэхжих явдал нь санхүүгийн тогтвортой байдлыг дээшлүүлэх, санхүүгийн салбарыг илүү хүртээмжтэй болгох,

өрсөлдөөнийг дэмжих, эдийн засгийг бүхэлд нь дэмжих, ядуурлын түвшнийг бууруулах нөлөөтэй.

Судалгааны хэсэг

Олон нийтийн дунд санхүү, эдийн засгийн мэргэжилтэй хүмүүсийг хувь хүний хувьд санхүүгийн боловсролтой иргэд гэж тодорхойлж мөн тэдгээр хүмүүс өөрсдийгөө санхүүгийн боловсролтой гэж мөн дүгнэж байна. Яг үүнтэй адилаар санхүү, эдийн засгийн чиглэлээр суралцдаг оюутнууд санхүүгийн боловсролтой байдаг гэсэн ойлголт ч байна.



Энэ байдлаас үндэслэн санхүүгийн боловсрол ба санхүүгийн мэдлэгийн төсөөтэй болон ялгаатай байдлыг харуулахын тулд эдийн засгийн сургууль болох “Мандах бүртгэл” дээд сургуулийн 30 оюутан, эрүүл мэндийн сургууль болох “Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль”-ийн 30 оюутан, урлагийн сургууль болох “Соёл урлагийн их сургууль”-ийн 30 оюутан, нийт 17-24 насны 90 залуучуудаас түүврийн аргаар санхүүгийн боловсролыг үнэлэх судалгаа авсан юм.

Санхүүгийн боловсролыг үнэлэх судалгааны асуулга нь олон улсын байгууллагуудаас хэрэгжүүлдэг санхүүгийн боловсролын байгууллагын хөтөлбөрийн судалгааны асуулга дээр үндэслэсэн бөгөөд үндсэн 5 хэсгээс бүрдсэн 24 асуулттай. Үүнд:

1. Мөнгөний талаарх ойлголт
2. Хуримтлал, хадгаламж
3. Зарцуулалт
4. Төсөв, төлөвлөгөө
5. Санхүүгийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн



Судалгааны үндсэн 5 хэсэг тус бүрээс 2 үндсэн асуултны үр дүнг харуулан тайлбарласан болно.

Нэг. Мөнгөний талаарх ойлголт





Мөнгөний ойлголтын талаарх судалгааны асуулгуудад 3 сургуулийн оюутнуудын дийлэнх хувь нь ижил хариулт өгсөн байна. Тэр дундаас онцгойлон авч үзвэл Мөнгө гэж юу вэ? асуулгын хувьд “Мандах бүртгэл” дээд сургуулийн оюутнууд мөнгийг “хэрэгсэл” талаас нь дүгнэх байх гэсэн хүлээлт байсан боловч санхүүгийн мэдлэг болон мэргэжлийн онцлогоос үл хамааран оюутнуудын дийлэнх хувь “хэрэгцээ” гэсэн хариултыг өгсөн байна.

Хоёр. Хуримтлал, хадгаламж





Хуримтлалын талаарх асуулгад 3 сургуулийн оюутнуудын дийлэнх хувь нь ижил байдлаар “Маш чухал”, “Чухал” гэсэн хариултыг сонгосон байгаа нь хуримтлалын ашиг тусын талаарх мэдлэгтэй байгааг харуулж байгаа ч дараагийн судалгааны үзүүлэлтээс харвал 3 сургуулийн оюутнуудын 30-40 хүртэлх хувь нь хуримтлал огт хийгээгүй болохыг харуулж байна.

Гурав. Зарцуулалт





Судалгааны зарцуулалт бүлгийн үзүүлэлтийг дүгнэвэл “Мандах бүртгэл” дээд сургуулийн оюутнууд зарцуулалтаа хянах тал дээр “Соёл урлагийн их сургууль” болон “Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль”-г бодвол харьцангуй өндөр гарсан бөгөөд арга аргачлалын хувьд оюутнуудын олонх нь зарцуулалтаа цээжээр тогтоодог ба ямар нэгэн тэмдэглэл хөтөлдөггүй болох нь харагдаж байна.

Дөрөв. Төсөв, төлөвлөгөө



Судалгаанд оролцогсдын дийлэнх хувь нь хувийн төсвөө зохиож хэрэгжүүлэх чухал гэсэн хариултыг өгсөн бөгөөд судалгаанд хамрагдсан сургуулиудын онцлогоос үл хамааран дийлэнх оюутнууд төсвийн бүрэлдэхүүн хэсгийг “Орлого, зарлага, хадгаламж”, “Орлого, зарлага” гэсэн хэсгээс бүрдэнэ гэсэн сонголтуудыг хийсэн байна.

Тав. Санхүүгийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн



Энэхүү судалгааны хэсгийн үзүүлэлтээс харвал нийт судалгаанд хамрагдсан оюутнуудын 70-80% нь банк, банкны үйлчилгээний талаар мэдлэгтэй байгаа бөгөөд “Эрсдэлээс хамгаалах аргуудаас нэрлэнэ үү?” гэх асуултанд нийт судалгаанд хамрагдсан оюутнуудын 10 хүрэхгүй хувь нь даатгал гэж хариулсан.

Дүгнэлт

Олон нийтийн дунд санхүүгийн байгууллагын ажилчид, санхүү эдийн засгийн чиглэлээр суралцдаг оюутнууд л санхүүгийн боловсролтой байдаг, тэрхүү санхүүгийн боловсрол энгийн иргэдийн хувьд сурахад хүнд хэцүү, тэр бүр сурах шаардлагагүй зүйл гэсэн үзэл бодол давамгайл байдаг. Тиймээс юуны түрүүнд олон нийтийн дундах тэрхүү буруу ташаа ойлголтыг залруулж санхүүгийн мэдлэг болон санхүүгийн боловсрол гэсэн ойлголтын ялгаатай байдал, ач холбогдолыг тодорхой харуулах нь чухал юм. Энэхүү жижиг судалгааны ажлаар санхүүгийн чиглэлээр суралцдаг тодорхой санхүү, эдийн засгийн хичээл үзсэн, санхүүгийн мэдлэгтэй болон өөр мэргэжлийн чиглэлээр суралцдаг оюутнуудын санхүүгийн боловсролын түвшин, байдлыг харьцуулан дараах дүгнэлтэд хүрлээ.

Судалгааны асуулгын үндсэн 5 хэсэг тус бүрт мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэх асуултууд багтсан бөгөөд санхүүгийн үйлчилгээ болон бүтээгдэхүүний талаарх онолын мэдлэгийн хувьд санхүү эдийн засгийн сургууль болох “Мандах бүртгэл” дээд сургуулийн оюутнууд илүү байсан. Хэдий тийм боловч тэрхүү онолын мэдлэгээ амьдралд ашиглах чадварын хувьд “Соёл урлагын их сургууль”, “Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль”-ийн оюутнуудтай ижил түвшинд байсан.

Онцгойлон авч үзвэл “Мандах бүртгэл” дээд сургуулийн оюутнуудын хувьд даатгалын үйлчилгээний талаарх мэдээлэл онолын мэдлэгийн хувьд илүү байсан ч “Та өөрийгөө эрсдэлээс хамгаалах арга мэдэх үү?” гэх асуултанд хамгийн өндөр хувьтайгаар “Үгүй” гэж хариулсан нь санхүүгийн мэдлэгтэй хүн, санхүүгийн боловсролтой хүний ялгаатай байдлыг тод харуулж өгсөн.

Энэхүү судалгаагаар санхүү, эдийн засгийн мэргэжлийн чиглэлээр суралцдаг оюутнууд цаашлаад санхүүгийн байгууллагын мэргэжилтэн, ажилтнууд нь санхүү, эдийн засгийн мэдлэгтэй, мэргэжилтэй байдаг боловч хувь хүн, иргэний хувьд санхүүгийн боловсролгүй байдаг гэж дүгнэж болох юм. Энэ байдал нь тухайн хувь хүн иргэнээс шалтгаалах хүчин зүйл багатай бөгөөд манай орны боловсролын системд санхүүгийн боловсролын хичээлийн агуулга байдаггүйтэй холбон үзэж болох юм байна. Тухайлбал: ЕБС-ийн Нийгмийн ухааны хичээлийн хөтөлбөрт эдийн засгийн, санхүүгийн суурь ойлголтуудыг бүхэлд нь үздэг боловч залуучууд онолын мэдлэг цээжлэхээс цааш суралцаагүй, тухайн онолын мэдлэг нь чадвар болж суугаагүй болохыг би өөрийн жишээн дээрээс дүгнэж болохоор байна.

Санал зөвлөмж

Монгол улсын санхүүгийн үйлчилгээний 97 хувийг нь банк, санхүүгийн үйлчилгээ эзэлдэг мөн судалгаанд хамрагдсан оюутнуудын 70-80 хувь нь банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг ашигладаг гэсэн үзүүлэлтийг үндэслэн банк санхүүгийн байгууллагууд нь өөрсдийн үйлчилгээгээр дамжуулан иргэдэд санхүүгийн суурь боловсрол олгох үйл ажиллагааг системтэй хамтран хэрэгжүүлбэл үр дүнтэй байх боломж харагдаж байна. Үүнээс үндэслэн банк санхүүгийн ажилтнуудын санхүүгийн суурь боловсролыг дээшлүүлэх сургалтын үйл ажиллагааг далайцтай нэн тэргүүнд явуулах шаардлага мөн харагдаж байна.

Мөн олон улсын санхүүгийн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлдэг туршлагыг судлаж байхад сургалтын хөтөлбөр нь бүтээлчээр суралцах, арга барил эзэмших, зөв хэвшил хандлагатай болгоход чиглэгдсэн байдаг байна. Иймээс “Олон нийтийн санхүүгийн суурь боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх санхүүгийн боловсролын хичээлийг заах сургагч багш нарын арга барилыг сайжруулах тухайлбал уламжлалт заах арга зүйг өөрчилж дан ганц санхүүгийн мэдлэг, ойлголт өгөх төдийгүй арга барил эзэмшсэн, чадвартай, итгэл үнэмшилтэй санхүүгийн боловсролтой иргэнийг бий болгоход чиглэх шаардлага харагдаж байна. Багш бэлтгэх шат шатны сургуулийн оюутан сурагчдад санхүүгийн боловсрол олгох хөтөлбөрийг нэн даруй оруулах нь зүйтэй юм, учир нь өөрөө санхүүгийн боловсролын ач холбогдлыг ойлгосон, үр өгөөжийг нь хүртсэн, хувийн амьдралдаа хэрэгжүүлдэг багш уг хөтөлбөрийн хичээлийг үр дүнтэй заах нэг үндэслэл болно гэдэг санал дээр дүгнэлтээс урган гарч байна.

Түүнчлэн их, дээд болон мэргэжлийн боловсрол олгодог сургуулийн суурь боловсролын хичээлийн хөтөлбөрт “Хувь хүний санхүүгийн боловсрол”-ын хичээлийн хөтөлбөрийг оруулж мэргэжил хамааралгүйгээр бүх оюутан залуучуудад санхүүгийн боловсрол олгох зайлшгүй хэрэгцээ байна гэж дүгнэж байна. Эдгээр нийгэмд бэлтгэгдэж буй залуусын нэгэн бүхэл бүтэн үеийг ийм түвшний санхүүгийн мэдлэг, боловсролтойгоор нийгэмд гаргана гэдэг нь харамсалтай байна. Иймээс юуны түрүүнд санхүүгийн боловсролын түргэвчилсэн сургалтын хөтөлбөр боловсруулж сургуулиудтай хамтран хэрэгжүүлэх нь зүйтэй болов уу. Ингэж чадсанаар эдийн засагт гарч буй өөрчлөлт, бодит нөхцөл байдалд өөрийн дүгнэлтийг өгч зөв бодитой шийдвэр гаргах чадвартай, санхүүгийн хариуцлагатай, санхүүгийн боловсролын ач холбогдол, үр өгөөжийг ойлгож мэдсэн мэргэжилтнүүд бэлтгэгдэн гарах бөгөөд эдгээр мэргэжилтнүүд нь цаашид санхүүгийн боловсролыг түгээх үйл ажиллагаанд салбар бүртээ, шат шатандаа дэмжлэг үзүүлэх болно гэдэгт итгэлтэй байна.

Энэхүү судалгаагаар санхүүгийн боловсролын хөтөлбөр хэрэгжихээс өмнөх оюутан залуучуудын санхүүгийн боловсролын түвшнийг тодорхойлох, тэдний чадамжийг үнэлэх боломжтой гэдэг нь харагдсан бөгөөд энэхүү суурь үнэлгээ нь “Олон нийтийн санхүүгийн суурь

мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн дараах үр дүнг үнэлэхэд ч ач холбогдолтой юм.

Ном зүй

Санхүүгийн зөв шийдвэр гаргах нөхцлийг бүрдүүлэх нь(2013)
Дэлхийн банк, <http://www.mongolbank.mn>

Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн суурь боловсролын өнөөгийн байдлын
оношлогоо дүгнэлт(2012) – Дэлхийн банк, <http://www.mongolbank.mn>;
<http://www.worldbank.org/>

Санхүүгийн чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөрийг МУ-д хэрэгжүүлэх нь
–Дэлхийн банк, <http://www.mongolbank.mn>; <http://www.worldbank.org/>

Global Financial Education Program: Young People: Your Future, Your Money
Microfinance Opportunities and Freedom from Hunger
www.MicrofinanceOpportunities.org

Aflateen manual of Social and Financial Education for Youth,
Aflatoun Child Savings International, www.aflatoun.org

<http://www.wikipedia.org/>